

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03-р сарын 18-ны өдөр

№ 25/14

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-г тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагт хосолсон /цахим болон танхим /хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах газрыг Компанийн оршин байрлах албан ёсны хаягт ойр байхаар буюу Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 5 давхрын хурлын өрөө байхаар тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - 3.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
 - 3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
 - 3.4. 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын А/04 дугаартай Хаалттай хүрээнд давуу эрхийн хувьцаа гаргах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай шийдвэрт өөрчлөлт оруулах;
 - 3.5. Бусад;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д үүрэг болгосугай;
6. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг тогтоолын Нэгдүгээр Хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз болон Компанийн цахим хуудсаар дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, зарын давталтыг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр болон 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй;

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталж, баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д үүрэг болгосугай;
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Саналын хуудасны агуулгыг Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, “Саналын хуудас”-ны загварыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулахыг Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д үүрэг болгосугай;
9. Компанийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс хойш Компанийн төв оффист ирж Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/, болон Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-т даалгасугай;
10. Үнэт цаасны брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-аар урьдчилан санал авах сүүлийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 16:00 цагт тасалбар болгохоор тогтоосугай;
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “Инвескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-г томилсугай;
12. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:
 - 12.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:

Б.Буд	Эрсдэлийн удирдлага, коплаенсын газрын захирал/ ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
-------	---
 - 12.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

М.Энхжин	Хуулийн зөвлөх/ТУЗ-ийн ажлын алба
Б.Амарбаясгалан	Хуулийн зөвлөх
Л.Тэмүүлэн	Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал
Д.Хонгорзул	Маркетингийн менежер
Т.Номундарь	Харилцагчийн үйлчилгээний менежер
Б.Алтанзагас	Хүний нөөцийн газрын захирал
Б.Мөнх-Эрдэнэ	Үйл ажиллагаа хариуцсан ахлах менежер
Б. Номинхүү	Төслийн менежер
Н.Дэлгэрмаа	Төслийн ахлах менежер
13. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:
 - 13.1. Тооллогын комиссын дарга:

Б.Ундрал “Инвескор Капитал ҮЦК” ХХК

 - 13.2. Тооллогын комиссын гишүүд:

Н.Даваажаргал	“Инвескор ББСБ” ХК Ахлах Аудитор
Б.Энхжин	“Инвескор ББСБ” ХК Зээлийн мониторингийн менежер
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг

Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/, Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б. Буд/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03-р сарын
18-ны өдрийн хурлын 25/14 тоот Тогтоолын Нэгдүгээр хавсралт

**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**



Компанийн оноосон нэр:	Инвескор ББСБ ХК
Хурлын төрөл:	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр, 14:00 цагт
Хурал хуралдах газар:	Инвескор Апплекейшн болон веб хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 5 давхрын хурлын өрөөнд танхимаар
Бүртгэлийн өдөр:	2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:	<ol style="list-style-type: none">1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг батлах;4. 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын А/04 дугаар Хаалттай хүрээнд давуу эрхийн хувьцаа гаргах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай шийдвэрт өөрчлөлт оруулах;5. Бусад;
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:	Хувьцаа эзэмшигчид нь 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд компани өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон Компанийн төв байранд ирж хурлын баримт бичигтэй танилцах боломжтой. Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:00-18:00 цагийн хооронд ажиллана.
Хурал хуралдах шийдвэр гаргасан этгээд, шийдвэрийн огноо, дугаар:	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 25/14 тоот тогтоол.
Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:	Хурлын комиссын дарга: Инвескор ББСБ ХК-ийн Эрсдэлийн удирдлага, комплаенсын газрын захирал/ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, bud@invescore.mn Хурлын комиссын гишүүд: <ol style="list-style-type: none">1. Хуулийн зөвлөх/ТУЗ-ийн ажлын алба, М.Энхжин, enkhjin@invescore.mn2. Хуулийн зөвлөх, Б.Амарбаясгалан, amarbayasgalan.b@invescore.mn3. Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал, Л Тэмүүлэн, temuulen.l@invescore.mn

	<ol style="list-style-type: none">4. Маркетингийн менежер, Д.Хонгорзул, <u>khongorzul.d@invescore.mn</u>5. Харилцагчийн үйлчилгээний менежер, Т.Номуундарь, <u>nomuundari@invescore.mn</u>6. Хүний нөөцийн газрын захирал, Б.Алтанзагас, <u>altanzagas@invescore.mn</u>7. Үйл ажиллагаа хариуцсан ахлах менежер, Б.Мөнх-Эрдэнэ, <u>munkherdene.b@invescore.mn</u>8. Төслийн менежер, Б. Номинхүү, <u>nominkhuu@invescore.mn</u>9. Төслийн ахлах менежер, Н.Дэлгэрмаа, <u>delgermaa.n@invescore.mn</u>
--	---



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03-р сарын
18-ны өдрийн хурлын 25/14 тоот Тогтоолын Хоёрдугаар хэсэглэлт

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн жагсаалт
1	“Инвескор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 25/14 тоот тогтоол;
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4	Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загвар;
5	“Инвескор ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
6	“Инвескор ББСБ” ХК-ийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
7	“Инвескор ББСБ” ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол;
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
9	“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийн санал;
10	Компанийн гаргасан Давуу эрхийн хувьцааны нөхцөлд өөрчлөлт оруулах санал;
11	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;

.....